

## “ТҮҮХ” ХИЧЭЭЛИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги:8  
Хугацаа: 80 минут  
Нийт оноо: 100  
даалгавар 70 оноо

Сурагчийн нэр:  
Нэгдүгээр хэсэг 35

Хоёрдугаар хэсэг 5

даалгавар 30 оноо

### Хувилбар-1

1. Түүхэн сурвалжид “Бага хаадын үе” гэж тэмдэглэсэн нь аль үеийг хэлж байна вэ? /2 оноо/
  - A. Хубилай хааны дараагийн үеийг
  - B. Улс төрийн бутралын үеийг
  - C. Манжийн эрхшээлийн үеийг
  - D. Чингисээс бусад хаадын үеийг
  - E. Чингис, Өгэдэй, Гүюг, Мөнх хаанаас бусад хаадын үеийг
2. 1686 онд Заг Байдрагийн Хүрэн бэлчирт болсон чуулганаар ямар асуудлыг хэлэлцсэн вэ? /2 оноо/
  - A. Монгол ойрадын их цаазыг батлах
  - B. Халх журам хуулийг батлах
  - C. Түшээт хан, засагт ханы ноёдыг хооронд нь эвлэрүүлэх
  - D. Халх, Ойрад хоёр бие даасан улс болохоо харилцан хүлээн зөвшөөрөх
  - E. Манжид дагаар орох
3. Түүхийн сурвалжуудад улс төрийн бутралын үеийн тухай өгүүлэхдээ хэрэглэдэг “дөчин, дөрвөн 2” хэмээх хэллэг ямар утгыг илэрхийлдэг вэ? /2 оноо/
  - A. Эзэн харьяатын ёс
  - B. Цэргийн зохион байгуулалт
  - C. Мал сүргийн харьцаа
  - D. Ар, Өвөр монгол
  - E. Зүүн, баруун монгол
4. Монголд шарын шашин дэлгэрсний хамгийн гол эерэг талыг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? /2 оноо/
  - A. Олон сүм хийд байгуулагдан, уран барилга, уран баримлын гайхамшигт дурсгалуудыг бүтээсэн
  - B. Олон эрдэмтэн мэргэд төрөн гарч, буддизмын олон ухаанаар бүтээлээ туурвисан
  - C. Хүмүүсийн оюун санааг чөлөөлсөн
  - D. Энэтхэг, Түвдийн соёл нэвтрэн, Монголын соёлыг Хятадын соёлоос хамгаалах үүрэг гүйцэтгэсэн
  - E. Дотоодын дайн самуун зогссон
5. Манжаас тогтоосон хуулиар монголын малчин ардуудыг суман ард, хамжлага ард, шавь ард, хэмээн гурав хуваан хамжлагачлахаар тогтоожээ. Хамжлага ард нь хэний хамжлага вэ? /2 оноо/
  - A. Монголын ноёд язгууртнуудын
  - B. Манжийн хааны /төрийн/
  - C. Манжийн амбаны
  - D. Хутагт хувилгаадын
  - E. С ба D зөв
6. XIX зууны II хагасаас Манж Чин улс Монголд шинэ засгийн бодлого (ШЗБ)-ыг хэрэгжүүлж эхэлжээ. Үүний улмаас Монголд гадаадын, ялангуяа Хятадын худалдаа мөнгө хүүллийн капитал хүчтэй нэвтэрч, ихээхэн хөгжсөн. Хятадын худалдаа мөнгө хүүллийн капитал нь Монголд эерэг болон сөрөг нөлөө үзүүлжээ. Монголын түүхэнд гүйцэтгэсэн гол эерэг нөлөө нь юу вэ? /2 оноо/
  - A. Монголын эдийн засгийг хөгжүүлсэн
  - B. Шинээр олон үйлдвэр аж ахуйн газар байгуулагдсан
  - C. Монгол дэлхийн зах зээлтэй холбогдож, таваар мөнгөний харилцаа хөгжсөн
  - D. Хятад, Монголын харилцаа сайжирсан
  - E. Монголын ард түмний аж байдал сайжрахад нөлөөлсөн
7. Юань улсын сүүлчийн хаан хэн бэ? /2 оноо/
  - A. Тогоонтөмөр
  - B. Лигдэн
  - C. Аюушридар
  - D. Есөнтөмөр
  - E. Хайсанхүлэг
8. Монгол уламжлалаар эцгийн гал голомтыг аль хөвгүүн нь өвлөн залгамжлах давуу эрхтэй вэ? /2 оноо/
  - A. Ахмад хүү
  - B. Отгон хүү
  - C. Аль ч хүү болно
  - D. Эцгийн нэр заасан (гэрээсэлсэн) хүү
  - E. Дунд хүү

9. Улс төрийн бутралын үед алтан ургийн биш нэг хүн хаан ширээнд суусан. Тэр хаан хэн бэ? /2 оноо/

- A. Тогоон      B. Эсэн      C. Адай      D. Аругтай      E. Мандуул

10. Газарзүйн ихнээлтийн эхэн үед "Каравелла" хөлөг онгоцыг зохин бүтээсэн улсыг нэрлэнэ үү? /2 оноо/

- A. Испани      B. Португали      C. Хятад      D. Кастилийн вант улс

11. Монголын эртний улсуудаас аль нь анх цолыг хэрэглэх болсон бэ? /2 оноо/

- A. Хүннү      B. Сяньби      C. Нирун      D. Түрэг

12. Шэлүнь хаан түүх, газар зүй, одон орон, зурхайн ухаан, бурхан шашны ном зохиол судалдаг хүн байсан нь эрт цагт Азид соёл, шинжлэх ухааны үр хөврөлүүд эрчимтэй явагдаж байсны тод жишээ юм. Шэлүнь аль улсын ямар цолтой хаан байсан бэ? /2 оноо/

- A. Монголын "Их хаан"      B. Хятадын Хан Улсын "Эзэн хаан"

- C. Их Нирун Улсын "Хутагтай цэцэн хаан"      D. Түрэгийн "Улсыг хураагч хаан"

13. Татарууд Охинбархагийг гэнэдүүлэн баривчилж Алтан улсад хүргүүлэн модон илжгэнд хадаж амийг нь хөнөөлгүүлсэн. Тэрбээр Хамаг Монголын хааны хэний нь хүү байсан бэ? /2 оноо/

- A. Хабул хаан      B. Амбагай хаан      C. Хотула хаан      D. Гүр хаан

14. XI-XII зууны үеийн Монгол ханлиг аймгуудын нийгмийн бүтцийг харахад жирийн иргэдийг урт дурын хүмүүс, харьяат зарц, өтөгү боол, онгу боол хэмээн ангилсан байдаг. Онгу боол гэж ямар хүмүүсийг хэлдэг вэ? /2 оноо/

- A. Эзний харьяанд цаггүй, хөлсгүй ажиллагсад

B. Боол байж байгаад эзэндээ үнэнч зүтгэж гавьяа байгуулаад чөлөөлөгдөж, онголсон хүмүүс

- C. Онгу хэмээх газраас боол бологсад

- D. Өтгөсийн үеэс үе дамжсан боол

15. Төр шашныг хослон барих хоёр ёсны тухай өгүүлсэн сэтгэлгээний бүтээлийг нэрлэнэ үү. /2 оноо/

- A. Ганжуур      B. Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх

- C. Хаадын үндэсний хураангуй Алтан товч судар оршив

- D. Эртний Монголын үндэсний их шар тууж оршив

16. XI-XII зууны үед язгуурын Монгол аймгууд Нирун ба Дарлигин гэсэн хоёр бүлэгт хуваагддаг байжээ. Дарлигин аймгууд гэж ямар овог аймгийнханийг нэрлэдэг вэ? /2 оноо/

A. Добу мэргэний бэлэвсэн хатан Алунгоогийн гурван ховгүүдийн удмаас үүсэлтэй овог аймаг

B. "Эргүнэ гүн" очсон Нукуз, Хиян хоёр овгоос үржин олон болсон Эргүнэ гүний Монголчууд

- C. Хамаг Монголоос бусад ханлиг аймгууд

- D. Хамаг Монголын ханлигийн бүрэлдэхүүнд багтах бүх овог, аймгууд

17. Эртний монголчууд бөөгийн шашин шүтэж ирсэн уламжлалтай билээ. Удган бөө гэж ямар хүнийг нэрлэж байсан бэ? /2 оноо/

- A. Эрэгтэй бөө      B. Эмэгтэй бөө      C. Зан үйл хийдэг хүн      D. Өндөр настай хүн

18. Түүх соёлын үнэт дурсгал бүхий гурван цэнхэрийн агуй хаана оршдог вэ? /2 оноо/

- A. Төв аймгийн Сэргэлэн сум      B. Өвөрхангай аймгийн Хархорин суманд

- C. Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд      D. Ховд аймгийн Манхан суманд

19. Монголын Нууц Товчоонд "Тэнгэрт нар сар хоёр гэрэлтэн, гэгээ болтугай хэмээн нар, сар хоёр байдаг буй за. Газарт хоёр хаан байж болох?" хэмээх үгийг хэн хэлсэн бэ? /2 оноо/

- A. Тэмүжин      B. Тоорил      C. Таян      D. Жамуха

20. Чингис хааныг залгамжлагчдаас хэн нь Алтан ордны улсыг үндэслэн байгуулсан бэ? /2 оноо/

- A. Мөнх хаан      B. Хүлэгү      C. Цагаадай      D. Зүчи

21. Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үйл хэрэгт хамгийн чухал тооцогдохыг олно уу. /2 оноо/

- A. Чингис хааны удам олон зуун жилийн турш төрийн эрх барьсан.

- B. Хархорумыг улсын нийслэл болгосон.

- C. Дэлхийн бусад оронтой худалдаа арилжааг өргөнөөр хийх болсон.

- D. Тархай бутархай Монгол олон аймаг, ханлигуудыг нэгтгэж, хүчирхэг Их Монгол улсыг байгуулсан.
22. Чингис хаан "Төрийн хар хайрцаг"-ны бодлогын нууцыг чандлан, залгамжлуулахаар хэнийг итгэмжилсэн бэ? /2 оноо/  
 A. Зүчи                      B. Цагаадай                      C. Өгөдэй                      D. Тулуй
23. Тэмүжин "Хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа цуглуулах" хэргийг үүсгэхдээ хэнийг анх түшиглэсэн бэ? /2 оноо/  
 A. Гурван мэргидийн Тогтоа Бэхи                      B. Хэрэйдийн Тоорил ван  
 C. Жадараны Жамуха                      D. Найманы Таян хаан
24. Чингис хааны бага хүү Тулуйн хүү Хүлэгүгийн байгуулсан улсыг түүхэнд юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
 A. Их Монгол улс                      B. Ил хант улс  
 C. Цагаадайн улс                      D. Султаны улс
25. XIII зууны Их Монгол Улсын нийслэл Хархорум хотын хааны ордоны өмнөх мөнгөн модыг хэн урласан бэ? /2 оноо/  
 A. Монгол дархан Төмөр                      B. Хятад дархан Жан  
 C. Франц дархан Вильгельм Бушье                      D. Унгарын дархан Жиованни
26. Монгол нутагт анхны төрт улсаа байгуулсан Хүннүгийн төрийн шашин юу байсан бэ? /2 оноо/  
 A. Бөөгийн шашин                      B. Бурханы шашин  
 C. Бумбын шашин                      D. Лалын шашин
27. Дэлхийн I дайн дахь "Гурвын Холбоо"-нд анх ямар ямар улсууд багтаж байсан бэ? /2 оноо/  
 A. Франц, Их Британи, Герман                      B. АНУ, Англи, Дани  
 C. Франц, Их Британи, Орос                      D. Их Британи, Япон, Герман
28. Дэлхийн II дайнд Герман улс бууж өгсөн буюу Европ дахь ялалтын өдрийг дугуйлна уу? /2 оноо  
 A. 1945.5.8                      B. 1944.5.7                      C. 1945.9.2                      D. 1946.5.9
29. Дэлхийн I дайны дараа Герман улсыг Версалийн ордонд ямар ч нөхцөл тавилгүй гарын үсэг зурахыг шаардсан "Версалийн гэрээ" байгуулагдсан оныг дугуйлна уу? /2 оноо/  
 A. 1918                      B. 1919                      C. 1917                      D. 1920
30. Ариун Елена аралд хэнийг бүх насаар нь цөлсөн бэ? /2 оноо/  
 A. В. Вильсоныг                      B. Наполеоныг                      C. Б. Артурыг                      D. Фирднандыг
31. Сайн хөршийн бодлогыг хэн явуулсан бэ? /2 оноо/  
 A. Сталин                      B. Д. Рузвельт                      C. Черчилль                      D. Рехард зорге
32. Зөвлөлт Орос улс хэдэн онд дэлхийн 1-р дайнаас гарсан бэ? /2 оноо/  
 A. 1918-03-03                      B. 1915-02-12                      C. 1915-08-23                      D. 1916-03-31
33. 800000 жилийн тэртээ монгол нутагт хүн амьдарч байсныг нотлох олдворууд хаанаас олдсон бэ? /2 оноо/  
 A. Хэнтий аймгийн Биндэр сумын Өглөгчийн гол  
 B. Төв аймгийн Баянцагаан сумын Баян-Айраг  
 C. Увс аймгийн Улаангом сумын Чандманий соёл  
 D. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
34. 15000-8000 жилийн тэртээх үе ямар зэвсгийн үед хамрагдах вэ? /2 оноо/  
 A. Неолит                      B. Мезолит                      C. Палеолит                      D. Хүрэл зэвсгийн үе
35. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүс нум сумыг хэдий үеэс амьдрал ахуйдаа хэрэглэх болсон бэ? /2 оноо/  
 A. Неолит                      B. Мезолит                      C. Палеолит                      D. Хүрэл зэвсгийн үе
36. Дараах түүхийн дурсгалт газруудын газар нутгийн хамаарлыг тохируулна уу. (A, B, C тус бүрт Харгалзах утгыг 1, 2, 3-аас сонгоно уу). /6 оноо/  
 A. Цагаан агуй    1. Хэнтийн Батширээт сум  
 B. Рашаан хад    2. Баянхонгорын Баянлиг сум  
 C. Хойд Цэнхэрийн агуй    3. Ховдын Манхан сум  
 A. A2, B1, C3,                      B. A1, B2, C3                      C. A2, B3, C1,
37. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /6 оноо/  
 A. Тайж                      1. Боржигон овгийн бус язгууртны толгойлогч  
 B. Хохь тайж                      2. Албат хамжлагагүй, хөрөнгө хогшил багатай

- |               |                                  |
|---------------|----------------------------------|
| C. Тайш       | 3. Чингис хааны удмын үр ач      |
| D. Хунтайж    | 4. Хаан ширээг залгамжлах хүү    |
| A.A2 B3 C1 D4 | B.A3 B2 C1 D4      C.A3 B2 C4 D1 |

38. . Монголын хууль цаазны түүхэнд холбогдох хуулиудыг харгалзах онтой нь тааруулна уу. /6 оноо/

- |                                                                  |            |
|------------------------------------------------------------------|------------|
| A. Дөчин дөрвөн хоёрын их цааз                                   | 1. 1918 он |
| B. Халх журам                                                    | 2. 1789 он |
| C. Юан төрийн хууль цаазын бичиг                                 | 3. 1709 он |
| D. Гадаад Монголын төрийг засаг явдлын яамны хууль зүйлийн бичиг | 4. 1320 он |
| E. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг          | 5. 1640 он |

- A. A5 B3 C4 D2 E1      B. A3 B5 C4 D2 E1      C. A5 B3 C4 D1 E2

39. Монголчууд эртнээс бичиг үсэг зохион хэрэглэж, номыг торгонд баринтаглан шүтэж ирсэн түүхтэй ард түмэн билээ. Хэн ямар бичиг үсэг зохиосныг зөв тохируулна уу. /6 оноо/

- |                   |                           |
|-------------------|---------------------------|
| A. Дөрвөлжин үсэг | 1. Өндөр гэгээн Занабазар |
| B. Тод үсэг       | 2. Дамдинсүрэн            |
| C. Соёмбо үсэг    | 3. Пагва лам              |
| D. Кирилл         | 4. Зая бандид Намхайжамц  |

- A. A3B4C1D2      B. A4B1C2D3      C. A4B2C1D3      D. A4B2C1D3

40. Монголын түүхэнд гарамгай зүтгэсэн 4 хүнийг нэрлэ. /6 оноо/

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....

**“ТҮҮХ” ХИЧЭЭЛИЙН ДЭВШИХ  
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Анги:8  
Хугацаа: 80 минут  
Нийт оноо: 100

Сурагчийн нэр:  
Нэгдүгээр хэсэг 35 даалгавар 70 оноо  
Хоёрдугаар хэсэг 5 даалгавар 30 оноо

**Хувилбар-2**

1. Улс төрийн бутралын үед алтан ургийн биш нэг хүн хаан ширээнд суусан. Тэр хаан хэн бэ? /2 оноо/  
А. Тогоон      В. Эсэн      С. Адай      D. Аругтай      E. Мандуул
2. Доорх хариултуудаас аль нь улс төрийн бутралын үеийн “түмэн” хэмээх засаг захиргааны нэгжийг илүү оновчтой тодорхойлж байна вэ? /2 оноо/  
А. 10 мянган цэрэг гаргах үүрэг бүхий засаг захиргааны нэгж  
В. 10 мянган хүнээс бүрдсэн засаг захиргааны нэгж  
С. Аравт, зуут, мянгат, түмт гэсэн 10-тын системийн нэг нэгж  
D. Ноёдын том эзэмшил  
E. Хэд хэдэн түмтээс бүрдэх их түмт
3. Түүхийн сурвалжуудад улс төрийн бутралын үеийн тухай өгүүлэхдээ хэрэглэдэг “дөчин, дөрвөн 2” хэмээх хэллэг ямар утгыг илэрхийлдэг вэ? /2 оноо/  
А. Эзэн харьяатын ёс      В. Мал сүргийн харьцаа      С. Зүүн, баруун Монгол  
D. Ар, Өвөр Монгол      E. Цэргийн зохион байгуулалт
4. 1640 онд Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Халх, Ойрад, Хөхнуур, Ижилмөрний Монголчуудыг Төлөөлсөн том ноёдын чуулган болсон. Чуулганы гол үр дүнг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? /2 оноо/  
А. Монгол Ойрадын их цаазыг баталсан  
В. Халх журам хуулийг баталсан  
С. Түшээт хан, Засагт ханы ноёдыг хооронд нь эвлэрүүлсэн  
D. Халх, Ойрад хоёр бие даасан улс болохоо харилцан хүлээн зөвшөөрсөн  
E. Манжид дагаар орох шийдвэр гаргасан
5. Манжаас тогтоосон хуулиар Монголын малчин ардуудыг суман ард, хамжлага ард, шавь ард хэмээн гурав хуваан хамжлагачлахаар тогтоожээ. Суман ард нь хэний хамжлага вэ? /2 оноо/  
А. Монголын ноёд язгууртнуудын      В. Тайж нарын      С. Хутагт хувилгаадын  
D. Ван, гүнгийн      E. Манжийн хааны (төрийн)
6. XIX зууны II хагасаас Манж Чин улс Монголд шинэ засгийн бодлого (ШЗБ)-ыг хэрэгжүүлж эхэлжээ. Монголд хэрэгжүүлсэн ШЗБ-ын мөн чанарыг аль нь илүү оновчтой илэрхийлж байна вэ? /2 оноо/  
А. Монголыг хөгжүүлэх  
В. Монголд оруулах Хятадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх  
С. Монгол дахь бусад гадаад орны капиталыг шахан зайлуулах  
D. Монголыг Оросоос тусгаарлах      E. Монголыг шууд колоничлох, хятадчилах
7. 1686 онд Заг, Байдрагийн Хүрэн бэлчирт болсон чуулганаар ямар асуудлыг хэлэлцсэн вэ? /2 оноо/  
А. Монгол, Ойрадын их цаазыг батлах  
В. Халх журам хуулийг батлах  
С. Түшээт хан, Засагт хан ноёдыг хооронд нь эвлэрүүлэх  
D. Халх, Ойрад хоёр бие даасан улс болохоо харилцан хүлээн зөвшөөрөх  
E. Манжид дагаар орох
8. Халх монголд байгуулагдсан буддын шашны анхны сүм хийд аль нь вэ? /2 оноо/  
А. Гандан      В. Заяын хийд      С. Амарбаясгалант  
D. Ламын гэгээний хийд      E. Эрдэнэ зуу
9. 1370-1634 буюу Аюушридараас Лигдэн хутагт хүртэлх хаадуудыг нийтэд нь юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
А. Бага хаад      В. Их хаад      С. Сүүлчийн хаад      D. Завсрын хаад      E. Балчир хаад
10. Африкийн эрэг дэх хошууг “Хар салхит хошуу” хэмээн нэрэлсэн далайчны нэрийг дугуйлана уу? /2 оноо/  
А. Бартоломе Диас      В. Васко да Гама      С. Христофер Колумб      D. Хэнри

11. Стандар ойл,Ройал датч зэрэг нь юуны нэр вэ? /2 оноо/  
 А. Газрын нэр В. Хотын нэр С. Компаний нэр D.Хүний нэр
12. Эртний Монгол аймгуудыг удмын талаас нь хэрхэн ангилан хуваадаг вэ? /2 оноо/  
 А. Дарилган ба Нирун В. Хиад Боржигон  
 С. Хатиган ба Баядууд D. Ойн ба талын
13. Судрын чуулганд Монголчуудын өвөг дээдсийг эрт цагт хаана амьдарч байсан хэмээн өгүүлдэг вэ? /2 оноо/  
 А. Эргүнэ Кун хэмээх газар В. Сэлэнгэ мөрний эхэнд  
 С. Гурван голын эхээр D. Аль нь биш
14. Түүхэнд нэр нь тэмдэглэгдэн үлдсэн Хамаг Монголын анхны хаан хэн бэ? /2 оноо/  
 А. Есүхэй В. Тэмүжин С. Амбагай D. Хабул
15. Өгөөдэй хаан төр барих үедээ 1247 онд авч явуулсан гол арга хэмжээ юу вэ? /2 оноо/  
 А. Татварын нэгдсэн систем тогтоох В. Өртөө байгуулав  
 С. Хүн малын тооллого явуулав. D. Цэргийн шинэчлэл болов
16. Чингис хаан Мэргидээс хэнийг хатан болгож авсан бэ? /2 оноо/  
 А. Бөртэ В. Есүй С. Есүгэн D. Хулан
- 17.Монголын Их Юань гүрний сүүлчийн хаан хэн бэ? 2 оноо  
 А. Төгстөмөр В. Хүслэн С. Тогоонтөмөр D. Өлзийт
- 18.Монголд шарын шашин дэлгэрэхэд гадны ямар улсууд нөлөөлсөн бэ? /2 оноо/  
 А. Түвд В. Манж С. Энэтхэг D. а, b зөв
19. Манж нар умардын Алтан улсыг хэдэн онд байгуулсан бэ? /2 оноо/  
 А. 1610 он В. 1616 С. 1620 он D. 1618 он
20. Хамаг монгол ханлигийн анхны хаан Хабулын дараа хэн хаан болсон бэ? /2 оноо/  
 А. Амбагай В.Хотула С. Есүхэй D. Бартан баатар
- 21.1246 онд Тамирын "Шар ордон"-д болсон Их хуралдайгаар хэн их хаанд өргөмжлөгдсөн бэ? /2 оноо/  
 А. Гүюг В. Хубилай С. Мөнх D. Аюушридар
22. 1691-1911 оны үеийг монголын түүхийн хамгийн гунигт үе гэж үздэг. Үүнтэй холбоотой өгөгдлийг ол. /2 оноо/  
 А. Төрийн тусгаар тогтнолоо алдсан В. Манжийн эрхшээлд орсон  
 С. Ертөнцөөс тусгаарлагдсан D. Нийгмийн хөгжлөөс хоцорсон
- 23.1370-1634 буюу Аюушридаргаас Лигдэн хутагт хүртэлх хаадуудыг нийтэд нь юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/  
 А. Бага хаад В. Их хаад С. Сүүлчийн хаад D. Завсрын хаад
24. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт "Цагаан байшин" хэмээх өргөө ордны туурь байдаг. Энэ нь өгөгдлийн алинд хамаарагдах вэ? /2 оноо/  
 А. Лигдэн хаан В. Галдан бошигт хаанС. Амарсанаа D. Цогттайж
- 25.Нууц задруулсан хэргээр Их Хуралдайд орох эрхээ хасуулсан хүн хэн бэ? /2 оноо/  
 А. Алтан В. Хучир С. Хасар D. Бэлгүтэй
26. Түүхийн судар бичиг, ном зохиолуудад тэмдэглэгдсэн Гурван голын монголчууд" хэмээх хэллэг байдаг. Энэ нь ямар утгыг илэрхийлдэг вэ? /2 оноо/  
 А. Нийт монголчууд В. Язгуурын монголчууд  
 С. Түрэгжсэн монголчууд D. Монголжсон түрэг аймаг
- 27 . В.И.Лениний байгуулсан "Большевик нам" хэдэн онд байгуулагдсан бэ? /2 оноо/  
 А. 1910 В. 1911 С. 1912 D. 1913
28. Эх орны дайны үеэр "Москвагийн төлөөх тулалдаан" хэдээс хэдэн оны хооронд явагдсан бэ? /2 оноо/  
 А. 1942-1943 В. 1944-1945 С. 1941-1942 D.1943-1944
29. Дэлхийн II дайнд улаан арми Берлин хотыг эзлэсэн хугацааг дугуйлна уу? /2 оноо/  
 А. 1943.5.5 В. 1944.5.2 С. 1945.5.2 D.1946.5.5
30. Нацистууд 6 сая гаруй жүдүүдийг устгасныг түүхэнд хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/  
 А. геноцид В. холокост С. террор D. антисемитизм
31. Рузвельт Черчилль нар хэдэн онд "Атлантын тунхаг" –ийг боловсруулсан бэ? /2 оноо/  
 А. 1942 В.1943 С.1944 D.1941
32. А.Гитлер хэдэн онд Германы канцлер болсон бэ? /2 оноо/  
 А.1933 В. 1923 С. 1929 D.1934

33. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүс нум сумыг хэдий үеэс амьдрал ахуйдаа хэрэглэх болсон бэ? /2 оноо/  
 А. Неолит                      В. Мезолит                      С. Палеолит                      D. Аль нь ч биш
34. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дах Оцон мааньтын дурсгал аль үеийн дурсгалд хамаарах вэ? /2 оноо/  
 А. Хуучин чулуун зэвсэг                      В. Дунд чулуун зэвсэг  
 С. Шинэ чулуун зэвсэг                      D. Хүрэл зэвсэг
35. Монгол нутгаас олдсон шинэ чулуун зэвсгийн үеийн бууц, суурингуудаас хамгийн томоохон нь хаанаас олдсон бэ? /2 оноо/  
 А. Ховдын Манхан сум  
 В. Дорноговь аймгийн Тамсагбулаг  
 С. Баянхонгор аймгийн Баянлиг  
 D. Дорнод аймгийн Халх гол
36. Улс төрийн бутралыг даван туулахыг Эсэн тайш хаан, Батмөнх даян хаан, Түмэн засагт хаан нар оролдсон хэмээн түүхэнд үздэг бөгөөд эдгээр хаадын авч явуулсан бодлого үйл ажиллагааг тохируулна уу. /6 оноо/  
 1. Эсэн тайш хаан                      а. Гар газар, хөл хөсөр байсан үе хэмээдэг  
 2. Батмөнх даян хаан                      b. Таван ханы төв засгийн газрыг байгуулсан  
 3. Түмэн засагт хаан                      c. 1452-1455 оны хооронд хаан ор суув  
 А. 1a, 2b, 3c.                      В. 1c, 2b, 3a                      С. 1c, 2a, 3b                      D. 1a, 2c, 3b.
37. . Монголчууд бичиг үсгийн арвин их түүхтэй ард түмэн мөн бөгөөд дундад үеийн түүхэндээ нэлээд хэдэн үсэг зохион хэрэглэж иржээ. Тэрхүү бичиг үсгийг зохиогчтой нь тохируулна уу. /6 оноо/  
 1. Дөрвөлжин үсэг                      а. Зая бандида Намхайжамц  
 2. Али гали галиг үсэг                      b. Пагва лам Лодойжалцан  
 3. Тод үсэг                      c. Харчины Аюуш гүүш  
 4. Соёмбо үсэг                      d. Агваан лам  
 5. Вагиндрагийн үсэг                      e. Өндөр гэгээн Занабазар  
 А. 1a, 2b, 3c, 4d, 5e                      В. 1d, 2c, 3a, 4b, 5e                      С. 1d, 2a, 3c, 4e, 5b                      D. 1b, 2c, 3a, 4e, 5d
38. Дараах өгөгдлүүдийг харгалзуулна уу? /6 оноо/  
 1. Өгөөдэй хаан                      а. Үлэмж жаргалангаар хүн амьтныг тэтгэж байсан  
 2. Хубилай хаан                      b. Гар газар, хөл хөсөр болов  
 3. Эсэн тайш хаан                      c. Их хуралдайгаар хаан сонгох журмыг эвдэж 1260 онд өөрөө хаан суув  
 4. Батмөнх даян хаан                      d. Хөлийг нь хөсөр, гарыг нь газар тавиулж жаргаая  
 5. Түмэн засагт хаан                      e. Эцгийн тайш цолыг залгамжлан улмаар хаан суув  
 А. 1b, 2d, 3e, 4a, 5c                      В. 1d, 2c, 3e, 4b, 5a                      С. 1a, 2b, 3d, 4c, 5e  
 D. 1c, 2e, 3a, 4d, 5b
39. Баруун зүг нүүдэллэсэн дараах улсуудын хэсэг тасархай хожим ямар нэрээр түүхэнд тэмдэглэсэн бэ? /Тохируул/ /6 оноо/  
 1. Хүннү                      А.Кара Китай  
 2. Нирун                      В. Гуннууд  
 3. Кидан                      С. Аварууд  
 А. 1C,2A,3B                      В. 1B, 2C,3A                      С. 1A, 2C, 3B
40. Монголын түүх, соёлын хамгийн гол 3 дурсгалын нэрийг бич. /6 оноо/  
 1. ....  
 2.....  
 3.....